



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 5/11

Өмнөдэлгэр сум

Ж.Энххуягийг ажилд улираан томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 56 дугаар зүйлийн 56.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар тогтоолын 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 05/4105 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул Жамъяндоржийн Энххуягийг 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн Гурванбаян тосгоны захирагчаар томилсугай.

2.Ж.Энххуягийн үндсэн цалинг 1,458,000 (нэг сая дөрвөн зуун тавин найман мянга) төгрөг, онцгой нөхцөлийн нэмэгдлийг үндсэн цалингийн 30 хувь, орон нутгийн нэмэгдлийг үндсэн цалингийн 60 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.



Р.ЭНХТӨР

[illegible][illegible][illegible]

၎င်းတို့သည် နေပြည်တော်ရှိ နေထိုင်သူများ၏ အသက်အရွယ်နှင့် အခြားအချက်များကို အခြေခံ၍ အသုံးပြုနိုင်ပါသည်။

50 20 5000

0/00

15/05/2016



የጥቅም ጥቅም

מלך המלכות